



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



Боловсрол, шинжлэх ухаан, оюуны ӨМЧ

Салбарын танилцуулга
2022 он

АГУУЛГА

АГУУЛГА.....	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
2022/2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЕРӨН ХИЙ ТОЙМ ҮР ДҮН.....	4
БҮЛЭГ I. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	7
1.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	8
1.2.2. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд	9
1.2.3. Хамран сургалт	11
1.2.4. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт	13
1.2.5. СӨБ-ын байгууллагын ажиллагчид	13
1.3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	15
1.3.1. Ерөнхий боловсролын сургууль	16
1.3.2. Суралцагчид	17
1.3.3. Нэгдүгээр ангид элсэгчид.....	20
1.3.4. Хамран сургалт	20
1.3.5. Төгсөгчид.....	23
1.3.6. Элсэлтийн ерөнхий шалгалт	24
1.3.7. Ажиллагчид.....	25
1.4. ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	27
4.1. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага	28
1.4.2. Суралцагчид	28
1.4.3. Шинээр элсэгчид	31
1.4.4. Төгсөгчид.....	32
1.4.5. Ажиллагчид.....	33
1.5. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	34
1.5.1. Дээд боловсролын сургалтын байгууллага	35
1.5.2. Суралцагчид	37
1.5.3. Шинээр элсэгчид	40
1.5.4. Төгсөгчид.....	41
1.5.5. Ажиллагчид.....	42
1.5.6. Гадаадын их, дээд сургуульд суралцагчид	44
1.6. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ	46

1.7. ШИНЖЛЭХ УХААН, ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	47
1.7.1. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт	48
1.7.2. Оюуны өмчийн салбарын үндсэн үзүүлэлт	49
БҮЛЭГ II. ДҮГНЭЛТ	52
ХАВСРАЛТ	53
1. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	53
1.1. Боловсролын тухай ойлголт, тодорхойлолт	53
1.2. Шинжлэх ухаан, оюуны өмчийн тухай ойлголт, тодорхойлолт	54
2. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР	56
3. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН АШИГЛАЛТ	56

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
АХС	Ажиллах хүчний судалгаа
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖТБИ	Жендэрийн тэнцвэрт байдлын индекс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс


2022/2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЕРӨН ХИЙ ТОЙМ ҮР ДҮН



БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК,

2022/2023 оны хичээлийн жилийн эхэнд

Орлогын
байгууллагын
байгууллага



БҮЛЭГ I. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.1 ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2021	2022	Өсөлт, бууралт, %
Цэцэрлэгийн тоо	1 453	1 413	-2.8
Ерөнхий боловсролын сургууль, тоогоор	848	859	1.3
Төрийн	682	688	0.9
Хувийн	166	171	3.0
Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, тоогоор	76	77	1.3
Их, дээд сургууль, коллеж, тоогоор	88	69	-21.6
Төрийн	20	16	-20.0
Хувийн	65	50	-23.1
Олон нийтийн / шашны өмчийн	3	3	-
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид	190 991	266 024	39.3
Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид	712 353	746 405	4.8
Бага анги	371 480	382 002	2.8
Дунд анги	238 348	251 347	5.5
Ахлах анги	102 525	113 056	10.3
Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчид	42 594	38 034	-10.7
Их, дээд сургууль, коллежид суралцагчид	148 954	145 267	2.5
Бүх шатны сургалтын байгууллагын үндсэн багш, мянган хүн	52.1	53.0	1.7
СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин, %	62.5	86.3	23.8
Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхэд	22	28	27.3
Бага боловсролын бүлэг дүүргэлт	32	32	-
Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, %	95.7	96.5	0.8
Дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, %	93.8	94.0	0.2
Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин, %	95.0	95.5	0.5
ЕБС-ийн нэгдүгээр ангид шинээр элсэгчид	75 518	78 728	4.3
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	20.3	20.7	2.0
Техникийн болон мэргэжлийн боловсролд суралцагчдын жөндөрийн тэнцвэрт байдлын индекс	67	60	-10.4
Техникийн болон мэргэжлийн боловсролд шинээр элсэгчид	22 554	19 256	-14.6
Их, дээд сургууль, коллежид суралцагчдын жөндөрийн тэнцвэрт байдлын индекс	157	157	-
Их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчид	30 545	26 316	-13.8
Улсын нэгдсэн төсвийн зарлагад боловсролын салбарын зардлын эзлэх хувь	11.4	13.1	1.7
ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь	4.0	3.8	0.2
Шинжлэх ухааны байгууллагын тоо	69	62	-10.1

Шинжлэх ухааны байгууллагын эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчид	5 907	5 982	1.3
Хүчинтэй байгаа ашигтай загвар, тоогоор	1 026	993	-3.2



1.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь тухайн хуульд “Бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино”¹ хэмээн тодорхойлсон.

Монгол Улсын хэмжээнд 2022/2023 оны хичээлийн жилд нийт цэцэрлэгийн тоо 1413 болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 40 (2.7%)-өөр буурахад цар тахлын үед хувийн өмчийн зарим цэцэрлэгүүд үйл ажиллагаагаа зогсоосонтой холбоотой бууралт юм.

Улсын хэмжээнд 2022/2023 оны хичээлийн жилд цэцэрлэгийн тоо 40-өөр буурсан хэдийч СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо 75.0 мянга (39.3%)-аар өсөхөд “Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах тухай” Засгийн газрын 218 дугаар тогтоолоор цэцэрлэгийн насны хүүхдийг хамран сургах, тойргийн цэцэрлэгт бүрэн хамруулах, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хороодод улсын цэцэрлэгийн салбар бүлгүүдийг нэмэлтээр байгуулсан нь СӨБ-ийн хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.

2022/2023 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгийн 985 (69.7%) нь төрийн өмчийн (Улаанбаатар төмөр замын харьяа 27 цэцэрлэг), 428 (30.3%) нь хувийн өмчийн цэцэрлэг байна. Нийт цэцэрлэгийн тоог 2021/2022 оны хичээлийн жилтэй харьцуулахад 40 (2.7%), хувийн өмчийнх 53 (11.0%)-аар тус тус буурч, төрийн өмчийнх 13 (1.3%)-аар нэмэгдсэн байна.


¹ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль: 3 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын зорилго

Зураг 1. Цэцэрлэгийн тоо, өмчийн хэлбэрээр



Улаанбаатар хотын цэцэрлэгийн тоо 2022/2023 оны хичээлийн жилд 666 болж 2021/2022 оны хичээлийн жилтэй харьцуулахад 28 (4.0) хувиар буурсан байна (Зураг 2).

Зураг 2. Цэцэрлэгийн тоо, бүсээр




1.2.2. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд

СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхдийн тоо 2022/2023 оны хичээлийн жилд 266.0 мянга болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 75.0 (39.3%) мянгаар өссөн байна.

СӨБ-ын байгууллагад 2022/2023 оны хичээлийн жилд 250.5 мянга (94.1%) нь үндсэн сургалтад хамрагдаж байгаа нь 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 72.0 мянга (40.4%)-аар өссөн байна.


2022/2023 оны хичээлийн жилд хувилбарт сургалтад хамрагдсан 15.6 мянган хүүхдийн 12.1 мянга нь нүүдлийн бүлэгт, 3.5 мянга нь явуулын багшийн сургалтаар дамжуулан сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

Зураг 3. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд, сургалтын төрлөөр




СӨБ-ын байгууллагад 2022/2023 оны хичээлийн жилд хамрагдсан хүүхдийн 231.6 мянга (87.1%) нь төрийн өмчийн цэцэрлэгт, 34.4 мянга (12.9%) нь хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна.

Зураг 4. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд, өмчийн хэлбэрээр



Сүүлийн 12 жилд СӨБ-д хамрагдсан 5 настай хүүхдийн хамран сургалтын хувь 89.1-93.5 болж өссөнийг дараах зургаас харж болохоор байна. 2022/2023 оны хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан 5 настай хүүхдийн хамран сургалтын хувь 93.5 хувь болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 2.2 нэгж хувиар өссөн байна.

Зураг 5. СӨБ-ын байгууллагад хамрагдсан 5 настай хүүхдийн хамран сургалтын хувь



Дараах зургаас харахад сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн тоо 2022/2023 оны хичээлийн жилд 1498 болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 433 (40.7%)-аар өсжээ.


Зураг 6. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо



1.2.3. Хамран сургалт


2022/2023 оны хичээлийн жилд 2-5 насны нийт хүүхдийн 86.3 хувь нь цэцэрлэгт хамрагдаж байгаа нь 2021/2022 оны хичээлийн жилээс 23.8 нэгж хувиар өссөн нь хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.

Зураг 7. Хамран сургалтын цэвэр жин, хувиар



Монгол Улсын 2-5 насны хүүхдээс СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувийг аймгаар авч үзвэл, Баян-Өлгий аймагт хамгийн бага (74.2%), Орхон аймагт хамгийн өндөр (93.3%) байна. СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувь Улаанбаатар хотод 88.1 хувь байна.


Зураг 8. СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувь, аймаг, нийслэлээр, 2022/2023 оны хичээлийн жилд



1.2.4. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт


Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 2022/2023 оны хичээлийн жилд улсын дунджаар 30 болж, 2021/2022 оны хичээлийн жилээс 6-гаар өссөн байна. Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас бүлэг дүүргэлтийг 20-25 байхаар зааж, 3 настай хүүхдийг цэцэрлэгт хамруулахгүй байх хоригийг цуцалсантай холбоотой юм.

Зураг 9. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт, хүүхдээр, бүлгээр, 2022/2023 оны хичээлийн жилд



2022/2023 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын цэцэрлэгийн нэг бүлэг дунджаар 30 хүүхэдтэй байна. Харин энэ үзүүлэлтийг дүүргээр харуулбал, нэг бүлэгт ногдох хүүхдийн тоогоор Баянзүрх, Налайх дүүрэг (32) хамгийн өндөр, Багануур дүүрэг (25) хамгийн цөөхөн нь байна.


Зураг 10. Улаанбаатар хотын цэцэрлэгийн бүлэг дүүргэлт, хүүхдээр, дүүргээр, 2022/2023 оны хичээлийн жилд



1.2.5. СӨБ-ын байгууллагын ажиллагчид


2022/2023 оны хичээлийн жилд СӨБ-ын байгууллагад нийт 32.5 мянган хүн ажиллаж байгаагийн 9.5 мянга буюу 29.1 хувь нь үндсэн багш, 8.3 мянга нь буюу 25.5 хувь нь туслах багш байна. 2021/2022 оны хичээлийн жилийнхээс үндсэн багшийн тоо 0.7 мянга (8.0%)-аар, харин туслах багшийн тоо 0.5 мянга (6.4%)-аар нэмэгдсэн байна.

Зураг 11. СӨБ-ын байгууллагын нийт ажиллагчид, мянган хүн



Улсын хэмжээнд 2022/2023 оны хичээлийн жилд нэг багшид 28 хүүхэд ногдож байна. Харин нэг багшид ногдох хүүхдийн тоогоор Дорноговь, Говь-Алтай, Сэлэнгэ аймаг (24) хамгийн бага байгаа бол Увс аймагт хамгийн өндөр (38) байна. Харин Улаанбаатар хотод 28 байна.

Зураг 12. Нэг багшид ногдох хүүхдийн тоо, аймаг, нийслэлээр, 2022/2023 оны хичээлийн жилд






1.3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.3.1. Ерөнхий боловсролын сургууль


2022/2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 859 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 74 (8.6%) нь бага сургууль, 109 (12.7%) нь дунд сургууль, 676 (78.7%) нь ахлах сургууль байна. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын 80.1 хувь нь төрийн өмчийн, 19.9 хувь нь хувийн өмчийн сургууль байна.

Зураг 13. Ерөнхий боловсролын сургууль, өмчийн хэлбэрээр



2022/2023 оны хичээлийн жилд нийт сургуулийн 562 (65.4%) нь хөдөөд, 297 нь (34.6%) хотод сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.


Зураг 14. Ерөнхий боловсролын сургууль, хот, хөдөөгөөр



1.3.2. Суралцагчид


2022/2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 746.4 мянган (өдрөөр 746.4 мянга, орой, эчнээгээр 127, дүйцсэн хөтөлбөрөөр 5.0 мянга) хүүхэд суралцсан байна.

Зураг 15. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид, сургалтын хэлбэрээр, дүнд эзлэх хувиар




2022/2023 оны хичээлийн жилд өдрөөр нийт 746.4 мянган хүүхэд суралцаж байгаагийн 91.6 хувь нь төрийн өмчийн сургуульд, 8.4 хувь нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна.

Зураг 16. Ерөнхий боловсролын сургуулийн өдрөөр суралцагчид, өмчийн хэлбэрээр




2022/2023 оны хичээлийн жилд ахлах ангид 113.1 мянган хүүхэд суралцаж байгаагийн 45.6 хувь нь хөвгүүд, 54.4 хувь нь охид байна.

Зураг 17. Ерөнхий боловсролын сургуулийн өдрөөр суралцагчид, 2022/2023 оны хичээлийн жилд



2022/2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 5.7 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа нь 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 67 (1.2%)-оор, өссөн байна.

Зураг 18. ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд



Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр 2022/2023 оны хичээлийн жилд 532 болж, 2021/2022 оны хичээлийн жилээс 16-аар буурч, 2011/2012 оны хичээлийн жилээс 20-оор тус тус нэмэгджээ.


2022/2023 оны хичээлийн жилд дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан 35.6 мянган хүүхдээс 35.1 мянга (98.5%) нь дотуур байранд амьдарч байгаа нь 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 4.2 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Зураг 19. Хүсэлт гаргасан нийт хүүхэд болон дотуур байранд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь



2022/2023 оны хичээлийн жилд ЕБС-д малчдын 132.6 мянган хүүхэд суралцаж байгаа нь 2021/2022 оны хичээлийн жилтэй харьцуулахад 4.4 мянга (3.4%)-аар нэмэгдсэн байна. Малчин өрхийн нийт хүүхдийн 35.1 мянга (26.4 %) нь дотуур байранд амьдарч байна.

Зураг 20. Хүсэлт гаргасан нийт хүүхэд болон дотуур байранд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь



1.3.3. Нэгдүгээр ангид элсэгчид

2022/2023 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр нийт 78.7 мянган хүүхэд элссэний 86.7 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

Зураг 21. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тоо болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь




1.3.4. Хамран сургалт

Хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо аль нэг боловсролын түвшний тухайн насны суралцагчдын тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулж тооцсон бөгөөд бага боловсролын (1-5-р анги) хамран сургалтын цэвэр жин 2022/2023 оны хичээлийн жилд 96.5 хувь болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 0.8 нэгж хувиар өссөн байна.


Дунд ангийн (6-9-р анги) хамран сургалтын цэвэр жин 2022/2023 оны хичээлийн жилд 94.0 хувь болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 0.2 нэгж хувиар өссөн байна.

Зураг 22. Хамран сургалтын цэвэр жин, хувиар



Улсын хэмжээнд бага боловсролын (1-5 дугаар анги) хамран сургалтын бохир жин (нас харгалзахгүйгээр тооцсон) 2022/2023 оны хичээлийн жилд 96.8 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 1.1 нэгж хувиар өссөн байна. Бага боловсролын хамран сургалтын бохир жинг аймгаар авч үзвэл, хамгийн өндөр нь Орхон аймагт (103.2 %), хамгийн бага нь Булган аймагт (90.2 %) байна.


Зураг 23. Бага боловсролын хамран сургалтын бохир жин, хувиар, аймгаар, 2022/2023 оны хичээлийн жилд



ЕБС-ийн нэг бүлэгт ногдох хүүхдийн тоо сүүлийн 9 жилийн хугацаанд аажмаар өсөж, 2022/2023 оны хичээлийн жилд улсын хэмжээнд нэг бүлэгт 30 хүүхэд, бага ангийн нэг бүлэгт 32 хүүхэд, дунд ангийн нэг бүлэгт 30, ахлах ангийн нэг бүлэгт 26 хүүхэд суралцаж байгаа нь улсын хэмжээнд тогтоосон стандартын² дагуу байна.


² БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалын 1.4-т заасан "Анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй байх"-аар тогтоосон.

Зураг 24. ЕБС-ийн бүлэг дүүргэлт, хүүхдээр



ЕБС-ийн бага боловсролын бүлэг дүүргэлтийг аймаг, нийслэлээр авч үзвэл, хамгийн их нь Улаанбаатар хот (36), Орхон аймагт (34), хамгийн бага нь Говь-Алтай аймагт (22) байна.


Зураг 25. ЕБС-ийн бага боловсролын бүлэг дүүргэлт, хүүхдээр, аймаг, нийслэлээр, 2022/2023 оны хичээлийн жилд



1.3.5. Төгсөгчид

2022/2023 оны хичээлийн жилд ЕБС-ийг нийт 92.7 мянган хүүхэд (9 дүгээр ангийг 59.6 мянга, 12 дугаар ангийг 33.1 мянга) өдрөөр суралцан төгссөн нь 2021/2022 оны хичээлийн жилээс 8.1 мянгаар өссөн байна.


Зураг 26. ЕБС-ийг нийт өдрөөр суралцан төгсөгчид, ангиар, 2012-2023 он



1.3.6. Элсэлтийн ерөнхий шалгалт

Их, дээд сургуульд 2023 онд элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүн буюу хэмжээст оноо (хэмжээст оноо гэдэг нь тухайн хичээлийн нийт гүйцэтгэлийг шалгалтад орсон шалгуулагчдын гүйцэтгэлтэй харьцуулан хэмжээслүүлсэн оноо)-г хүйсээр авч үзвэл, охид монгол хэл, нийгмийн ухаан, орос хэл, физик, газарзүйн хичээлүүд дээр хөвгүүдээс өндөр оноо авсан байна.

Зураг 27. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн (хэмжээст оноо), хүйсээр, 2023 он



1.3.7. Ажиллагчид

Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчдын тоо 2022/2023 оны хичээлийн жилд 57.7 мянга болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 1.5 мянга (2.7%)-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Ерөнхий боловсролын сургуулийн нийт ажиллагчид болон үндсэн багшийн тоо

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Ажиллагчид	44 618	45 363	45 367	45 882	46 791	47 168	47 991	49 441	51 550	54 498	56 228	57 737
Үндсэн багш	26 492	26 863	27 205	27 449	28 490	28 889	29 242	30 411	32 085	34 073	35 110	36 118
Бага ангийн	8 916	8 895	8 795	8 901	9 877	9 976	10 238	10 736	11 030	11 467	11 820	12 107
Дунд ангийн	11 217	10 877	11 184	11 233	11 454	11 708	11 960	12 670	13 703	14 694	15 399	16 108
Ахлах ангийн	6 359	7 091	7 226	7 315	7 159	7 205	7 044	7 005	7 352	7 912	7 891	7 903

2022/2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 36.1 мянган үндсэн багш ажиллаж байгаагийн 29.5 мянга (81.8%) нь эмэгтэй багш байна.


Үндсэн багш нарыг насны бүлгээр авч үзвэл 30-39 насныхан хамгийн их буюу 13.1 мянга (36.3%) байгаа бол 60 ба түүнээс дээш насны 718 (2.0%) үндсэн багш байна.


Хүснэгт 2. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн тоо

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Үндсэн багш	26 492	26 863	27 205	27 449	28 490	28 889	29 242	30 411	32 085	34 073	35 110	36 118
Эмэгтэй	21 717	21 936	22 051	22 285	23 120	23 479	23 876	24 879	26 149	27 729	28 642	29 546
Боловсролын зэргээр												
Доктор	21	28	15	23	22	23	23	19	18	25	30	31
Магистр	3 013	3 144	3 220	3 670	4 085	3 983	4 034	4 347	4 767	5 373	5 959	8 049
Бакалавр	17 647	18 354	19 065	19 441	20 142	20 949	21 185	22 301	23 722	26 024	26 644	25 124
Диплом	5 685	5 236	4 732	4 263	3 916	3 530	3 131	2 901	2 721	2 580	2 340	2 093
Бусад	126	101	173	52	325	404	869	843	857	71	137	821
Насны бүлгээр												
30 нас хүртэл	8 651	8 444	8 370	8 222	8 469	8 378	8 331	8 606	8 912	9 147	9 058	9 061
30-39 нас	9 067	9 422	9 686	10 011	10 277	10 406	10 526	10 741	11 361	12 339	12 913	13 110
40-49 нас	5 505	5 455	5 519	5 688	6 056	6 520	6 807	7 317	7 820	8 482	8 794	9 210
50-59 нас	3 114	3 353	3 447	3 369	3 515	3 389	3 365	3 462	3 607	3 650	3 823	4 019
60, түүнээс дээш	155	189	183	159	173	196	213	285	385	455	522	718
Ажилласан жилээр												
1 жил хүртэл	1 138	1 205	934	611	2 110	1 675	1 732	1 838	2 072	2 013	2 092	2 175
1-5 жил	6 531	6 116	6 585	8 196	8 869	9 405	9 287	9 919	8 296	9 279	9 272	9 373
6-10 жил	5 918	6 256	6 554	6 974	5 740	5 892	5 866	5 752	7 705	7 573	7 258	7 287
11-15 жил	3 666	3 851	4 115	4 158	4 785	4 348	4 576	4 825	5 307	5 686	5 808	5 781
16-20 жил	2 422	2 455	2 524	2 465	2 321	2 669	2 900	3 082	3 348	3 836	4 382	4 699
21-25 жил	2 636	2 584	2 312	1 979	1 396	1 420	1 446	1 562	1 733	1 993	2 245	2 423
26, түүнээс дээш	4 181	4 396	4 181	3 066	3 269	3 480	3 435	3 433	3 624	3 693	4 053	4 380

2022/2023 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ЕБС-ийн нэг багшид 21 хүүхэд ногдож байгаа бол бага ангийн нэг багшид 32 хүүхэд ногдож байна. Харин нэг багшид ногдох хүүхдийн тоог аймгаар авч үзвэл, Баян-Өлгий, Говь-Алтай аймагт хамгийн бага (15) байгаа бол Дорнод, Сүхбаатар аймагт (21), Дорноговь аймагт (22), Улаанбаатар хотод хамгийн өндөр (23) байна.

Зураг 28. Сурагч-багшийн тооны харьцаа (нэг багшид ногдох сурагчийн тоо), аймаг, нийслэлээр, 2022/2023 оны хичээлийн жилд






1.4. ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тоо 2022/2023 оны хичээлийн жилд 77 болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 1 (1.3%)-ээр нэмэгдсэн байна.

Зураг 29. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр




2022/2023 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсролын 77 сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагийн 62.3 хувь нь төрийн өмчийнх, 37.7 хувь нь хувийн өмчийнх байна.

1.4.2. Суралцагчид

Суралцагчдын тоо 2011-2017 онуудад тасралтгүй буурсан бол 2018/2019 оны хичээлийн жилээс бага зэрэг өсөж, 2022/2023 оны хичээлийн жилд 38.0 мянга болсон байна.


Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 23.8 мянга (62.5%) эрэгтэй суралцагчид байсан бол 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 1.8 мянга (6.9%)-аар буурсан байна.

Зураг 30. Нийт суралцагчид, хүйсээр



Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоог аймгаар авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд суралцагчдын 19.1 мянга (50.3%) нь Улаанбаатар хотод, 2.3 мянга (5.9%) нь Дархан-Уул аймагт, 1.3 мянга (3.5%) нь Төв аймагт, 1.2 мянга (3.2%) нь тус бүр Баянхонгор болон Ховд аймагт, 12.9 мянга (33.8%) нь бусад аймагт суралцаж байна.


Зураг 31. Нийт суралцагчид, аймгаар, хүйсээр, 2022/2023 оны хичээлийн жилд



Мэргэжлийн боловсролд суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдал (ЖТБ³)-ын индекс буюу мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 2022/2023 оны хичээлийн жилд 60 байна.


³ Жендэрийн тэнцвэрт байдлын индекс нь тухайн шатны боловсролыг эзэмшиж буй 100 эрэгтэй тутамд ногдох эмэгтэйн тоог харуулна.

Зураг 32. Жендэрийн тэнцвэрт байдлын индекс




Суралцагчдыг сургалтын төрлөөр нь авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд нийт 38.0 мянган суралцагчдын 33.0 мянга (86.8%) нь мэргэжлийн боловсролд, 4.8 мянга (12.5%) нь техникийн боловсролд, 0.3 мянга (0.7%) нь мэргэжлийн сургалтад суралцаж байна.

Зураг 33. Нийт суралцагчид, сургалтын төрлөөр




Суралцагчдын тоог салбараар авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 11.8 мянга (31.1%) нь аж үйлдвэрийн салбарын мэргэжлийг, 7.6 мянга (20.0%) нь барилгын салбарын мэргэжлийг тус тус сонгон суралцсан байна. Харин эрүүл мэндийн чиглэлээр 298 (0.8%) суралцагч суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 44 (17.3%)-аар өссөн байна.

Зураг 34. Нийт суралцагчид, мэргэжлийн чиглэлээр



Тээвэр, уул уурхай, барилгын салбаруудыг эрэгтэй оюутан илүүтэй сонгон суралцаж байгаа бол эмэгтэй оюутнууд эрүүл мэнд, үйлчилгээний салбарт илүүтэй суралцаж байна.

Зураг 35. Нийт суралцагчид, хүйсээр, салбараар, дүнд эзлэх хувиар, 2022/2023 оны хичээлийн жилд



1.4.3. Шинээр элсэгчид

2022/2023 оны хичээлийн жилд техникийн болон мэргэлийн боловсролын байгууллагад шинээр элсэгчдийн 7.8 мянга (40.6%) нь тухайн жилд суурь боловсрол эзэмшигчид байна.


Зураг 36. Шинээр элсэгчид, тухайн жилд суурь боловсрол эзэмшигчид



1.4.4. Төгсөгчид

2022/2023 оны хичээлийн жилд нийт 19.9 мянган оюутан төгссөн нь 2021/2022 оны хичээлийн жилээс 2.3 мянга (10.4%)-аар буурсан байна.


Зураг 37. Нийт төгсөгчид, хүйсээр



1.4.5. Ажиллагчид

Үндсэн багшийн тоо 2022/2023 оны хичээлийн жилд 4094 болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 150 (3.8%)-аар өссөн байна.

Зураг 38. Ажиллагчид болон үндсэн багш






1.5. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.5.1. Дээд боловсролын сургалтын байгууллага

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2022/2023 оны хичээлийн жилд 69 болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 19 (21.6%)-өөр буурахад хувийн өмчийн сургуулийн тоо өмнөх оноос 15 (23.1%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ,

Их дээд сургуулийн тоо буурахад Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор төрийн өмчийн 8 их, дээд сургууль, коллежийн ангиллыг өөрчлөн, нэгтгэн зохион байгуулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн А/296 дугаар тушаалаар хувийн өмчийн 15 их, дээд сургууль коллежийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон зэрэг нь нөлөөлсөн.


Зураг 39. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, суралцагчид



Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоог өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2011/2012 оны хичээлийн жилд нийт их, дээд сургууль, коллежийн 86 (85.1%) нь хувийн өмчийн, 15 (14.9%) нь төрийн өмчийн сургууль эзэлж байсан бол 2022/2023 оны хичээлийн жилд 50 (72.5%) хувийн өмчийн, 16 (23.2%) төрийн өмчийн, харин 3 (4.3%) нь олон нийтийн/шашны өмчийн⁴ сургууль байна.

⁴ Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн маягт 2020 онд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор байгууллагын өмчийн хэлбэрийн ангилалд өөрчлөлт орж, олон нийтийн/шашны өмчийн гэсэн ангилал нэмэгдсэн болно.

Зураг 40. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр



2022/2023 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын нийт 69 байгууллагын 47.8 хувь нь их сургууль, 50.7 хувь нь дээд сургууль, 1.4 хувь нь коллеж эзэлж байна.

Зураг 41. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, ангиллаар



1.5.2. Суралцагчид

Их, дээд сургууль, коллежид суралцагчид 2022/2023 оны хичээлийн жилд 145.3 мянга болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 3.7 мянга (2.5%)-аар буурсан байна.

Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 88.8 мянга (61.1%) нь эмэгтэй суралцагчид болсон нь 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 2.2 мянга (2.4%)-аар буурсан байна.


Хүснэгт 3. Нийт суралцагчид, аймгаар, хүйсээр, 2022/2023 оны хичээлийн жилд

Аймаг, нийслэл	Суралцагчид	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	145 267	56 444	88 823
Улаанбаатар	135 993	53 504	82 489
Баян-Өлгий	83	11	72
Говь-Алтай	896	161	735
Завхан	220	94	126
Увс	105	39	66
Ховд	1 215	414	801
Архангай	478	36	442
Баянхонгор	69	33	36
Орхон	1 405	546	859
Дархан-Уул	3 653	1 365	2 288
Дорноговь	497	75	422
Өмнөговь	69	41	28
Дорнод	554	111	443
Хэнтий	30	14	16

Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг аймгаар авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд нийт 145.3 мянган суралцагч суралцаж байгаагаас 56.4 мянга (38.9%) нь эрэгтэй, 88.8 мянга (61.1%) нь эмэгтэйчүүд байна. Харин 136.0 мянга (93.6%) нь Улаанбаатар хотод, 3.7 мянга (2.5%) нь Дархан-Уул аймагт, 5.6 мянга (3.9%) нь бусад аймагт суралцаж байна.


2022/2023 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн бакалаврын хөтөлбөрт 112.5 мянган оюутан хамрагдагсан байна. Тус хөтөлбөрт хамрагдагчдыг насны ангиллаар авч үзвэл 67.7 мянга (60.2%) нь 18-21 насныхан, 25.0 мянга (22.3%) нь 22-26 насныхан 7.1 мянга (6.3%) нь 27-30 насныхан, 5.5 мянга (4.9%) нь 31-34 насныхан, 3.6 мянга (3.2%) нь 35-39 насныхан, 2.1 мянга (1.9%) нь 40-49 насныхан, 0.3 мянга (0.3%) нь 50-аас дээш насныхан байна.

Зураг 42. Бакалаврын хөтөлбөрт хамрагдагчид, нийт дүнд эзлэх хувиар, насны ангиллаар, 2022/2023 оны хичээлийн жилд



Дээд боловсролын байгууллагад суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс буюу дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 2022/2023 оны хичээлийн жилд 157 байгаа нь 2021/2022 оны хичээлийн жилийнхтэй ижил түвшинд байна.

Зураг 43. Жендэрийн тэнцвэрт байдлын индекс



Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 112.5 мянга (77.4%) нь бакалавр⁵, 25.5 мянга (17.6%) нь магистр, 4.5 мянга (3.1%) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна. Суралцагчдын тоог 2021/2022 оны хичээлийн жилийнхтэй харьцуулахад бакалаврынх 4.6 мянга (3.9%)-аар буурсан бол магистрынх 209 (0.8%)-өөр, докторынх 1.0 мянга (30.2%)-аар тус тус өссөн байна.

⁵ Бакалаврын зэргийн суралцагчдад дипломын дээд боловсролын зэргийн суралцагчдыг оруулсан.

Хүснэгт .4 Нийт суралцагчид, боловсролын зэргээр

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Бүх суралцагчид	172 798	175 591	174 075	178 295	162 626	157 138	155 248	157 625	148 446	147 293	148 954	145 267
Үүнээс: Эмэгтэй	101 557	102 427	101 783	102 520	93 674	91 526	90 094	93 552	90 573	89 463	91 034	88 823
Дипломын дээд	-	-	-	-	-	-	124	362	98	124	3 155	2 799
Үүнээс: Эмэгтэй	-	-	-	-	-	-	21	191	14	17	2 519	2 221
Бакалавр	154 876	155 801	152 708	155 839	140 296	133 223	130 484	130 545	119 203	119 108	117 037	112 451
Үүнээс: Эмэгтэй	90 227	90 103	88 399	88 457	79 790	76 753	74 883	76 394	71 622	71 375	69 803	67 258
Магистрантур	14 873	16 630	18 063	19 065	19 005	20 066	20 345	22 499	25 753	24 813	25 300	25 509
Үүнээс: Эмэгтэй	9 505	10 420	11 437	12 103	11 957	12 552	12 697	14 554	17 066	16 291	16 717	16 742
Докторантур	3 049	3 160	3 304	3 391	3 325	3 849	4 295	4 219	3 392	3 248	3 462	4 508
Үүнээс: Эмэгтэй	1 825	1 904	1 947	1 960	1 927	2 221	2 493	2 413	1 871	1 780	1 995	2 602


Нийт суралцагчдыг мэргэжлийн чиглэлээр авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд хамгийн олон сурагч буюу 41.0 мянга (28.2 %) нь бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн чиглэлээр суралцаж байгаа бол хамгийн бага буюу 2.2 мянга (1.5%) нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлгийн салбарын мэргэжлийг сонгон суралцаж байна.

Зураг 44. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйс, мэргэжлийн ерөнхий чиглэл, нийт суралцагчдын тоонд эзлэх хувь, 2022/2023 оны хичээлийн жилд



Монгол Улсад 2022/2023 оны хичээлийн жилд нийт 3593 гадаад оюутан суралцаж байгаагийн 87.7 хувь хөрш зэргэлдээ БНХАУ-ын оюутнууд байна.

Зураг 45. Монгол Улсад суралцаж буй гадаад оюутан, нийт дүнд эзлэх хувиар, улсаар, 2022/2023 оны хичээлийн жилд



1.5.3. Шинээр элсэгчид


2022/2023 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид 26.3 мянган оюутан шинээр элссэн байгаагийн 16.5 мянга буюу 62.9 хувь нь эмэгтэй байна.

Зураг 46. Шинээр элсэгчид, хүйсээр



Элсэгчдийн дотор тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь 2022/2023 оны хичээлийн жилд 75.4 хувь болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 7.2 нэгж хувиар буурсан байна.


Зураг 47. Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэгчид, тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс элссэн байдал



1.5.4. Төгсөгчид

Их, дээд сургууль, коллежийг 2022/2023 оны хичээлийн жилд 23.3 мянга болж, 2021/2022 оны хичээлийн жилээс 9.6 мянга (29.2%)-аар буурсан байна. 2022/2023 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 14.9 мянга (64.2%) нь эмэгтэй байна.

Зураг 47. Нийт төгсөгчид, хүйсээр



Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд 23.3 мянга (74.0%) нь бакалавр⁶, 4.9 мянга (20.8%) нь магистр, 92 (0.4%) нь докторын зэрэг эзэмшсэн байна. 2011/2012 оны хичээлийн жилээс бакалаврын төгсөгчид 15.8 мянга (40.0%)-аар, докторынх 7 (7.1%)-аар буурч, магистрынх 1234 (34.0%)-аар өссөн байна.

⁶ Бакалаврын зэргээр төгсөгчдөд дипломын дээд боловсролын зэргээр төгсөгчдийг оруулсан.

Хүснэгт 5. Нийт төгсөгчид, боловсролын зэргээр

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Бүх төгсөгчид	37 749	37 243	33 850	35 181	35 889	34 681	29 164	23 038	28 045	31 161	32 925	23 314
Үүнээс: Эмэгтэй	24 339	23 949	21 662	21 857	21 848	21 179	17 476	13 513	17 262	19 861	21 122	14 973
Дипломын дээд	918	1 181	259	93	231	495	45	409	268	117	627	1102
Үүнээс: Эмэгтэй	655	910	121	25	128	364	17	68	96	90	497	908
Бакалавр	33 106	32 234	29 477	29 728	30 663	30 301	25 120	18 951	23 081	25 727	26 240	17 260
Үүнээс: Эмэгтэй	21 211	20 521	18 799	18 410	18 529	18 379	14 932	11 195	14 112	16 056	16 554	10 969
Магистр	3 626	3 697	3 996	5 254	4 859	3 772	3 868	3 574	4 531	5 273	5 954	4 860
Үүнээс: Эмэгтэй	2 412	2 434	2 676	3 358	3 104	2 374	2 446	2 185	2 959	3 687	4 012	3 045
Доктор	99	131	118	106	136	113	131	104	165	44	104	92
Үүнээс: Эмэгтэй	61	84	66	64	87	62	81	65	95	28	59	50

Зураг 48. Нийт төгсөгчид, хүйс, мэргэжлийн чиглэлээр, нийт төгсөгчдийн тоонд эзлэх хувь, 2022/2023 оны хичээлийн жилд




Нийт төгсөгчдийг мэргэжлийн чиглэлээр авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд 23.3 мянган төгсөгчдийн 8.3 мянга (35.8%) нь эрэгтэй, 15.0 мянга (64.2%) нь эмэгтэйчүүд байна. Нийт эрэгтэй төгсөгчдөөс 2.0 мянга (69.3%) нь инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын мэргэжлийн хамгийн ихээр сонгон суралцаж байхад харин эмэгтэйчүүд эрүүл мэнд нийгмийн халамж, боловсрол, урлаг, хүмүүнлэг, бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн чиглэлийг 64.7-86.2 хувь нь эмэгтэйчүүд дийлэнх байна.

1.5.5. Ажиллагчид


Их, дээд сургууль, коллежийн ажиллагчдын тоо 2022/2023 оны хичээлийн жилд 11.9 мянга болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 252 (2.1%)-аар буурсан байна.

Зураг 49. Их, дээд сургууль, коллежийн ажиллагчид, өмчийн хэлбэрээр




Их, дээд сургууль, коллежийн үндсэн багшийн тоог хүйсээр авч үзвэл, 2022/2023 оны хичээлийн жилд 3.2 мянга (61.3%) нь эмэгтэй багш байгаа нь 2021/2022 оны хичээлийн жилийнхтэй ижил түвшинд байна.

Зураг 50. Их, дээд сургууль, коллежийн үндсэн багш, эрэгтэй, эмэгтэй багшийн дүнд эзлэх хувиар



2022/2023 оны хичээлийн жилд нэг багшид 28 оюутан ногдож, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 4.0 нэгж хувиар өссөн байна.


Зураг 51. Нэг багшид ногдох суралцагчид



1.5.6. Гадаадын их, дээд сургуульд суралцагчид


Засгийн газар хоорондын хэлэлцээрийн, төрийн сангийн зээлээр 2022 онд гадаадын их, дээд сургуульд нийт 508 оюутан элссэний 68.7 хувь нь Засгийн Газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу, 31.3 хувь нь Боловсролын зээлийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцаж байна.

Зураг 52. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, төрийн сангийн зээлээр гадаадын их, дээд сургуульд суралцагчид



Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 2022 онд суралцаж буй 508 суралцагчдыг суралцаж буй улсаар нь харуулбал Хятад улсад 48.2 хувь, Унгар улсад 27.2 хувь нь, ОХУ-д 5.1 хувь нь, Польш, Вьетнам улсад тус бүр 3.9 хувь нь, АНУ-д 3.1 хувь нь, Лаос улсад 2.2 хувь нь суралцаж байгаа бол Англи, Франц, Тайвань, Япон, Канад, Австрали, Украин, Казахстан, Израйль, Болгар, Кипр, Куба улсад 0.2-1.2 хувь нь суралцаж байна.

Зураг 53. Засгийн Газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцагчид, суралцаж буй улсаар, 2022/2023 он




1.6. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвөөс боловсролын салбарт 2022 онд 410.0 тэрбумд хүрч, 2021 оныхоос 10.0 (2.5%)-аар өссөн байна. Монгол Улсын засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор хувьсах зардлын дундаж норматив, аргачлалд эрүүл мэндийн үйлчилгээний зардал, цахим хэрэглээний зардал шинээр нэмэгдэж батлагдсан. Мөн мэргэжлийн болон техникийн боловсролын статистик мэдээллийг хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хариуцан гаргадаг байсан. 2022 оноос эхлэн Боловсрол, шинжлэх ухааны яам хариуцдаг болсон тул сургалтын зардал нэмэгдсэн зэрэг шалтгаан нөлөөлсөн.

Улсын нэгдсэн төсвийн зарлагын дүнд боловсролын салбарын зардлын эзлэх хувийг авч үзвэл 2022 онд 13.1 хувь болж, 2021 оныхоос 1.7 нэгж хувиар өссөн. Харин дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсролын салбарын зардлын эзлэх хувь 2022 онд 3.8 хувь болж, 2021 оныхоос 0.2 нэгж хувиар буурсан байна.

Зураг 54. Улсын нэгдсэн төсвийн зарлага болон ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь






1.7. ШИНЖЛЭХ УХААН, ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.7 ШИНЖЛЭХ УХААН, ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.7.1. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт

Шинжлэх ухааны 62 байгууллага 2022 онд үйл ажиллагаа явуулсан байна. Шинжлэх ухааны салбарын нийт зардал 2022 онд 55.1 тэрбум төгрөг байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.1 хувийг эзэлж байгаа нь 2021 оныхтой ижил түвшинд байна.

Зураг 55. ДНБ-д шинжлэх ухааны салбарын зардлын эзлэх хувь



2022 онд шинжлэх ухааны байгууллагад нийт 6.0 мянган үндсэн ажиллагчид байгаагийн 60.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 6. Эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчид

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Үндсэн ажиллагчид	2 583	2 672	2 694	2 724	2 515	2 211	3 482	3 246	3 352	6 109	5 907	5 982
Эмэгтэй	1 368	1 409	1 388	1 411	1 277	1 132	1 932	1 565	1 700	3 573	3 570	3 644
Шинжлэх ухааны доктор	127	124	143	135	95	77	130	109	136	153	133	139
Боловсролын доктор	478	487	486	496	495	432	797	706	657	1 697	2 000	1 611
Академич	50	48	48	46	38	32	46	56	38	64	57	63
Профессор	167	157	176	166	125	77	221	157	136	369	436	326
Дэд профессор	116	117	116	106	98	74	239	187	166	564	666	593

Улсын төсвөөс 2022 онд нийт 366 эрдэм шинжилгээний ажлыг санхүүжүүлсний 83.9 хувийг суурь судалгааны ажил төсөл эзэлж байна.

Хүснэгт 7. Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа хөгжүүлэлтийн ажил


Судалгааны ажлын төрөл	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Бүгд	454	453	506	429	366	319	276	320	309	353	456	366
Суурь судалгааны ажил*	270	271	333	271	206	160	94	131	94	265	393	307
Хэрэглээний судалгааны ажил *	148	145	141	135	160	159	169	189	215	78	47	37
Туршилт, хөгжүүлэлтийн ажил*	36	37	32	23	-	-	13	-	-	10	16	22

*ШУТ-ийн салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээний маягт, аргачлал 2020 онд шинэчлэгдсэнтэй холбоотойгоор үзүүлэлтүүд шинэчлэгдсэн.

1.7.2. Оюуны өмчийн салбарын үндсэн үзүүлэлт

Иргэн, хуулийн этгээдээс 2022 онд ирүүлсэн 384 бүтээлд патент олгосны 118 нь шинэ бүтээлийнх, 266 нь бүтээгдэхүүний загварынх байгаа нь өмнөх оноос шинэ бүтээлийн патент 68 (36.6%)-аар буурч, харин бүтээгдэхүүний загварын патент 45 (20.4%)-аар өсжээ.


Зураг 56. Патент



Тайлбар: Оюуны өмчийн патентын мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргадаг тул тухайн бүрт олгосон патент нь патентын мэдүүлгээс их байж болно.

Оюуны өмчийн байгууллагад ашигтай загварын гэрчилгээ авахаар 2022 онд 99 иргэн, хуулийн этгээд мэдүүлэг гаргасан нь өмнөх оноос 74 (42.8%)-өөр буурчээ. Мөн иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн 59 ашигтай загварт гэрчилгээ олгосон нь өмнөх оноос 48 (44.9 %)-аар буурсан байна.

Зураг 57. Ашигтай загвар



Бүтээлээ зохиогчийн эрхээр хамгаалуулахаар 2022 онд иргэн, хуулийн этгээдээс нийт 996 мэдүүлэг гаргаснаас бүх бүтээлд шинээр зохиогчийн эрхийн гэрчилгээ олгосон нь өмнөх оноос 118 (10.6%)-аар буурчээ.

Хүснэгт 8. Зохиогчийн эрх, төрлөөр

Төрөл	2018	2019	2020	2021	2022
Зохиогчийн эрхийн нийт мэдүүлэг	1 072	1 007	1 060	1 114	996
Шинжлэх ухаан, утга зохиолын бүх төрлийн аман болон бичмэл бүтээл	938	748	763	511	430
Хөгжмийн урлагийн үгтэй болон үггүй бүх төрлийн бүтээл	40	6	106	299	29
Дүрслэх урлаг, уран баримал, график урлагийн бүх төрлийн бүтээл, эдгээрийн зураг төсөл	21	65	43	70	88
Уран барилга, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, цогцолбор болон архитектурын бусад бүтээл	15	14	30	74	14
Чимэглэх болон хавсрага урлаг, тайз чимэглэлийн бүх төрлийн бүтээл, эдгээрийн зураг төсөл	2	1	-	85	6
Жүжиг, бүжиг, уран нугаралт, пантомим зэрэг тайзны урлагийн бүх төрлийн бүтээл	-	14	7	55	3
Гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээл	1	3	-	7	5
Кино урлагийн болон бусад дуу авиа бүхий дүрст бүтээл	35	46	46	2	56
Газрын зураг, атлас болон архитектурын зураг төсөл, хар зураг, бүдүүвч, диаграм, гурван хэмжээст илэрхийлэл зэрэг шинжлэх ухаан техникийн шинжтэй тайлбар зураг	-	-	-	-	6
Компьютерын програм	-	-	-	-	193
Үүсмэл бүтээл	18	39	18	4	33
Мэдээллийн сан	-	-	-	-	4
Материалыг нь сонгон түүвэрлэх, байршуулах зэргээр бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бий болсон, өөрийн бүтэц агуулгаараа оюуны бүтээлд тооцогдох тайлбар толь, лавлах, зохиолын цоморлиг, түүвэр зохиол болон эмхэтгэл	2	69	47	6	129
Ардын урлагийн бүтээлд тулгуурлан туурвисан үүсмэл бүтээлийн төрөлд хамаарах бүтээл	-	2	-	1	-
Бусад зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааг илэрхийлэхүйц бүтээл	-	-	-	-	-
Зохиогчийн эрхээр хамгаалах бүтээлд олгосон гэрчилгээ	1 072	1 007	1 060	1 114	996

Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар хүчинтэй 55.5 мянган барааны тэмдэгт байна. Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт авахаар 2022 онд 3923 иргэн, хуулийн этгээд мэдүүлэг гаргасан байна. Нийт мэдүүлсэн барааны тэмдгийн 1777 (45.3%) нь Мадридын хэлэлцээрийн дагуу Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг байна. Мөн иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн 3496 барааны тэмдэгт эрхийн хамгаалалт олгосон нь өмнөх оноос 188 (5.7%)-аар өсөж, 1463 барааны тэмдгийг бүртгэхээс татгалзсан байна.

Хүснэгт 9. Барааны тэмдэг болон газарзүйн заалт

Үзүүлэлт	Барааны тэмдэг				
	2018	2019	2020	2021	2022
Нийт барааны тэмдэг болон газар зүйн заалтын мэдүүлэг	4 374	4 603	4 190	4 642	3 923
Дотоодын мэдүүлэг	1 431	1 581	1 663	2 222	1 663
Иргэн	354	480	529	725	490
Хуулийн этгээд	1 077	1 101	1 134	1 497	1 173
Гадаадын мэдүүлэг	576	619	529	502	483
Иргэн	5	20	7	7	20
Хуулийн этгээд	571	599	522	495	463
Олон улсын мэдүүлэг ¹	2 367	2 403	1 998	1 918	1 777
Иргэн	10	58	52	79	27
Хуулийн этгээд	2 357	2 345	1 946	1 839	1 750
Нийт эрхийн хамгаалалт олгосон барааны тэмдэг болон газар зүйн заалт	3 505	3 927	4 028	3 308	3 496
Бүртгэхээс татгалзсан	1 157	588	1 809	1 796	1 463
Хүчинтэй байгаа барааны тэмдэг	45 696	47 983	50 809	51 784	55 480

¹Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт авахаар Мадридын хэлэлцээр болон Протоколын дагуу мэдүүлсэн Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг.

БҮЛЭГ II. ДҮГНЭЛТ

- (СӨБ)-д хамрагдсан хүүхдийн тоо 266.0 мянга болж өмнөх оноос 75.0 (39.3%) мянгаар өссөн нь Е-монголиа цахим системээр харьяаллын дагуу хүүхдийг 100 хувь бүртгэж, цэцэрлэгт хамруулах бодлогыг хэрэгжүүлснээс шалтгаалж хамран сургалт эрс нэмэгдсэн байна. Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дэргэд салбар бүлэг байгуулж, ачаалал ихтэй дүүргийн хувийн цэцэрлэгт хувьсах болон хоолны зардлыг нэмэгдүүлэн олгосон. Мөн байгууллагын, түрээсийн, цомцог гэр зэргээр цэцэрлэгийн олон хэлбэрийг бий болголоо. Үүний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь улсын дүнгээр (86.3%) болж өмнөх оноос 23.8 нэгж хувиар өссөн. Аймгийн түвшинд авч үзвэл СӨБ-д хамрагдалт Баян-Өлгий аймагт хамгийн бага (74.2%), Орхон аймагт хамгийн өндөр (93.9%) байна. СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувь Улаанбаатар хотод (88.1%) боллоо.
- Суурь боловсролыг 2022/2023 онд 59593 сурагч өдрөөр суралцан төгссөний 13.1 хувь нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагад шинээр элссэн байна. Иймд суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдөөс мэргэжлийн болон техникийн боловсролд суралцагчдын тоог тогтмол нэмэгдүүлэх нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйчүүд, ядуурлыг бууруулахад эергээр нөлөөлөх юм.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад 2022/2023 оны хичээлийн жилд суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд 60 эмэгтэй ногдож байгаа бол дээд боловсролд суралцаж буй 100 эрэгтэй оюутан тутамд 157 эмэгтэй ногдож байгаа нь жендэрийн тэнцвэрт байдал алдагдаж буйг харуулж байна.
- Дээд боловсролын сургалтын байгууллага нийслэлд төвлөрдөг. Жилд дунджаар 30-40 мянган хүүхэд дунд сургууль төгсдөг. Үүний 40 хувь нь Улаанбаатар хотод, 60 хувь нь орон нутагт боловч төгсөгчдийн 91 хувь нь Улаанбаатар хотын сургуулиудад, зөвхөн 9 хувь нь орон нутгийн сургуульд элсэж байгаа нь орон нутагт суралцах оюутны хувьд мэргэжлийн сонголт хязгаарлагдмал байгаатай холбоотой байна. Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийг голчлон эзэмшиж байгаа мэргэжлийн чиглэлээр авч үзвэл Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй, инженер, үйлдвэрлэл, барилга угсралт, Эрүүл мэнд, нийгмийн халамж, Боловсролын мэргэжил тэргүүлж байна. Төгсөгчдийг хүйсээр авч үзэхэд инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын чиглэлээр төгсөгчдийн дийлэнх (69.3 хувь) нь эрэгтэй, эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол, урлаг, хүмүүнлэг, бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн салбарт 64.7-86.2 хувь нь эмэгтэйчүүд дийлэнх байв. Дээд боловсролын сургалтын байгууллагын байршлаас үл хамааран хөдөө, орон нутагт чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулж, бүс нутаг, орон нутгийн нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулах, хот хөдөөгийн ялгааг багасгах асуудал тулгарч байна.
- ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь 3.8 хувь, шинжлэх ухааны салбарын эзлэх хувь 0.1 байна.

1. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Боловсролын тухай ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэж заасан.

Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг ойлгоно гэж тодорхойлсон.

Боловсролын түвшин: сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг ойлгоно.

Албан боловсрол: Боловсролын сургалтын байгууллагаар дамжуулж, эрх бүхий байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу суралцагчийн боловсрол эзэмших, үр дүнг боловсролын баримт бичгээр баталгаажуулдаг зохион байгуулалттай үйл ажиллагаа юм.

Албан бус боловсрол: Иргэн, хуулийн этгээдээс хүний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагаа юм.

Насан туршийн суралцахуй: Хүн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг ойлгоно.

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино.

“Ерөнхий боловсрол” гэж бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсрол юм.

Мэргэшил гэж хөдөлмөр эрхлэхэд шаардагдах чадамжийг хэлнэ /Монгол Улсын “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай” хууль/.

Мэргэжлийн боловсрол гэж мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж эзэмших боловсролын түвшнийг хэлнэ гэж тодорхойлжээ /Монгол Улсын “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай” хууль/.

Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь, нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино. Дээд боловсролын сургалтын байгууллага нь коллеж, дээд сургууль, их сургууль байна.

Хамран сургалтын бохир жинг тооцохдоо нас харгалзалгүйгээр боловсролын тухайн түвшинд суралцагчдын тоог энэ түвшний боловсрол эзэмших насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо аль нэг боловсролын түвшний тухайн насны суралцагчдын тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Сурагч-багшийн тооны харьцааг боловсролын тухайн түвшний боловсролын байгууллагад суралцагчдын тоог энэ түвшний багшийн тоонд харьцуулж тодорхойлно.

Сургуульд суралцах хугацаа гэж тухайн насны суралцагчийн ирээдүйд суралцах жилийн нийлбэр болно. Тухайн суралцагчийн тодорхой насандаа сургуульд элсэн орох магадлал нь одоогийн хамран сургалтын жинтэй тэнцүү гэж үздэг.

Жендэрийн тэнцвэрт байдлын индекс гэж тодорхой нэг үзүүлэлтийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн тоон харьцааг ойлгоно.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсролын төсвийн зардлын эзлэх хувь гэж тайлант хугацаанд улсын төсвөөс боловсролын салбарт зарцуулж байгаа урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг хэлнэ. Боловсролын салбарт зарцуулж байгаа нийт зардлыг тооцохдоо холбогдох бүх яам, бүх шатны засаг захиргааны байгууллага, агентлаг, бие даасан институтийг хамарна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагад боловсролын төсвийн зардлын эзлэх хувь гэж Улсын төсвөөс боловсролын салбарт зарцуулсан нийт зардлыг тухайн жилийн улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Эмэгтэй багш нарын эзлэх хувь гэж нэг хичээлийн жилд тухайн боловсролын түвшинд ажиллаж байгаа эмэгтэй багш нарын нийт багшийн дүнд эзлэх хувь болно.

1.2. Шинжлэх ухаан, оюуны өмчийн тухай ойлголт, тодорхойлолт

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа: Эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн боловсрол олгох болон шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ үзүүлэх цогц үйл ажиллагааг хэлнэ.

Шинэ технологи: Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц юм.

Шинэ биет бүтээгдэхүүн: Биет шинж чанартай, эзэмшигчдээ онцгой эрх, эдийн засгийн үр өгөөж авчирдаг хөрөнгө.

Эрдмийн зэрэг: Судалгаа хөгжүүлэлтийн ажилд оролцсон ажиллагчдыг эрдмийн зэргээр ангилан бичнэ.

Эрдэм шинжилгээний ажилтан: Шинжлэх ухаан, технологийн тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэдэг мэргэшсэн судлаачийг хэлнэ.

Шинжлэх ухааны доктор: Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг хэлэлцэн Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Монгол Улсын шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн тушаалаар олгодог эрдмийн зэрэгтэй СХА-д оролцсон ажилтныг хамруулна.

Боловсролын доктор: Их сургууль зэрэг судалгааны чиг баримжаатай мэргэжлийн боловсролын байгууллагуудад шинэлэг, дэвшилтэт судалгааны ажил гүйцэтгэсэн суралцагчдад олгодог эрдмийн зэрэг юм. Докторын хөтөлбөрүүд нь шинжлэх ухааны болон мэргэжлийн салбараар төрөлждөг.

Суурь судалгаа: Аливаа үзэгдэл, ажиглаж болохуйц баримт, нотолгоонд түшиглэн, шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн, тодорхой хэрэглээнд анхнаасаа ашиглахыг зориогүй, туршилтын буюу онолын судалгааны ажил юм. Суурь судалгаа нь судлагдахууны шинж чанар, бүтэц, өөр хоорондын харилцан хамааралд дүн шинжилгээ хийх замаар таамаглал,

онол, зүй тогтлыг шинээр томьёолох, туршихад чиглэнэ. Хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг бий болгоход чиглэсэн туршилтын болон онолын үйл ажиллагааг ойлгоно (Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.3-р заалт).

Хэрэглээний судалгаа (хавсарга судалгаа): Тодорхой үр дүн гаргахад чиглэсэн, шинэ мэдлэг бий болгох зорилготой судалгааны ажил бөгөөд суурь судалгааны ололт, үр дүнг тодорхой хэрэглээнд ашиглаж болох эсэхийг тодорхойлох, тодорхой зорилгод хүрэх арга замыг тогтооход чиглэгдэнэ. Хэрэглээний судалгааны үр дүн нь тодорхой бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, арга зүй, тогтолцоонд ашиглагдахад зориулагдсан байдаг (Фраскатын гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).

Туршилт, хөгжүүлэлтийн ажил: Шинэ бараа, материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн шинэ үйл явц, тогтолцоо, үйлчилгээг нэвтрүүлэх, эдгээрийг сайжруулахад чиглэсэн системтэй судалгаа, туршилтын ажлыг ойлгоно (Фраскатын гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).

Оюуны өмч: Оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект болон аж үйлдвэрийн өмчийг ойлгоно (Монгол Улсын Оюуны өмчийн тухай хуулийн 3.1.1).

Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт: Иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно (Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3.1.1).

Зохиогчийн эрхийн гэрчилгээ: Зохиогчид өөрсдийн уран зохиолын болон урлагийн бүтээлүүдийн эзэмших эрхийг ашиглахад хэрэглэдэг хуулийн нэр томьёо юм. Зохиогчийн эрхийн бүтээлд ном, хөгжим, уран зураг, уран баримал, кино, компьютерийн програм, мэдээллийн сан, зар сурталчилгаа, газрын зураг, техникийн зураг зэрэг бүтээл багтдаг.

Газарзүйн заалтын эрхийн хамгаалалт: Тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн тодорхойлолт юм (Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3.1.4 заалт).

Патент: Тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг ойлгоно (Монгол Улсын -ын Патентийн тухай хуулийн 3.1.4-р заалт).

Шинэ бүтээл: Байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг ойлгоно (МУ-ын Патентийн тухай хуулийн 3.1.1).

Бүтээгдэхүүний загвар: Бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг ойлгоно (Монгол Улсын -ын Патентийн тухай хуулийн 3.1.2).

Ашигтай загвар: Үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно (Монгол Улсын -ын Патентийн тухай хуулийн 3.1.3).

2. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Боловсролын салбарын статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь Боловсрол, шинжлэх ухааны захиргааны статистикийн мэдээлэл байдаг. Түүнчлэн 10 жил тутам явагддаг ХАОСТ болон өрхөд суурилсан түүвэр судалгаанууд (АХС, ӨНЭЗС, НҮТС гэх мэт)-аас боловсролын статистикийн үзүүлэлтийг тооцон гаргаж байна. Боловсролын статистикийн захиргааны мэдээллийг тогтоосон хугацаанд цэцэрлэг, бүх шатны боловсролын байгууллагаас цуглуулдаг.

Мөн шинжлэх ухааны салбарын статистик мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны яамны захиргааны маягтын дагуу жилд нэг удаа, оюуны өмчийн статистикийн мэдээллийг Оюуны өмчийн газраас хагас, бүтэн жилээр албан ёсны маягтын дагуу цуглуулж байна.

3. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН АШИГЛАЛТ

Боловсролын статистик нь хүний амьдралын чанарын болон улс орны хөгжлийн чухал үзүүлэлтүүдийг бүрдүүлдэг. НҮБ-ын Статистикийн хүрээлэнгээс 2009 онд хэвлэн гаргасан боловсролын үзүүлэлтүүдийн техникийн гарын авлагыг үндэслэн боловсролын статистикийн үзүүлэлт тооцох үндэсний аргачлалыг 2013 онд батлан, уг аргачлалын дагуу үзүүлэлтүүдийг тооцон гаргаж байна.

Түүнчлэн олон улсын боловсролын стандарт ангилал (ISCED 2011)-д нийцүүлэн Монгол Улсын боловсролын ангилал, кодыг 2013 онд баталж, тооллого, судалгаа болон боловсролын бусад мэдээлэлд ашиглаж байна.

Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмчийн статистик мэдээллийг батлагдсан маягтаар цуглуулж, хагас, бүтэн жилийн бюллетень, танилцуулга, жилийн эмхэтгэлд тусган нийтийн хүртээл болгож байна.

Статистикийн эдгээр мэдээллийг бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг дүгнэх, салбарын нэмэгдэл өртгийн тооцоо хийх, хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцох, Тогтвортой хөгжлийн зорилт, бүх нийтийн боловсрол (Education for all) хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд, Хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцоход ашиглаж байгаагаас гадна ЮНЕСКО-гоос жил бүр гаргадаг эмхэтгэлд боловсролын салбарын хүртээмжийн, үр ашгийн, үр дүнгийн, санхүүгийн болон хүний нөөцийн үзүүлэлтийг боловсруулан аргачлалын дагуу тооцон оруулж байна.